



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 431

Улаанбаатар хот

### Заавар батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1.2, 38.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, зааврыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, зааврыг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, орон нутгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт даалгасугай.

Гурав. Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн сангийн газар /С.Наранцогт/-т, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Ганбат/-т үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

000972

Сангийн сайдын ..... дны ... дугаар сарын  
... өдрийн ..... тоот тушаалын хавсралт

Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх  
баримт бичгийн жишиг, заавар

### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү зааврын зорилго нь Төсвийн тухай хууль болон төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгддөг эрх зүйн актын хэрэгжилтийг хангуулах, төсвийн сахилга батыг сайжруулах, төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд үндэслэсэн анхан шатны баримтыг нягтлан бодох бүртгэлийн хуульд нийцүүлэн тайлангийн бүрдүүлбэр болгоход оршино.
- 1.2 Төсвийн тухай хуульд заасан төсвийн шатлалд хамаарах бүх шатны төсөвт байгууллага, зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, Засгийн газраас баталсан хөтөлбөрийн урсгал болон хөрөнгийн зардлын төлбөрийг төрийн сангаар дамжуулан гүйцэтгэхэд энэхүү зааврыг мөрдлөг болгоно.

### ХОЁР. Ерөнхий шаардлага

- 2.1. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан төлбөрийн хүсэлтийн хяналтын хэсэгт төлбөр гүйцэтгэхэд үндэслэх баримтын нэр, дугаар, огноог тодорхой бичнэ. Энэ нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүртгэл статистикийн асуудал эрхэлсэн байгууллагын хамтран баталсан нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтууд, тухайн төлбөрийг гүйцэтгэх эрх олгосон тушаал, шийдвэр, төсөв, үнэлгээний хорооны шийдвэр, гэрээ зэрэг баримт нотолгоо байна.
- 2.2. Төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсанд заасан төлбөр гүйцэтгэхэд үндэслэх баримтуудыг эх хувиар нь ирүүлнэ.
- 2.3. Төлбөр гүйцэтгэхэд үндэслэх баримт нь түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан албан тушаалтаны гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага бүрэн хариуцна.

### ГУРАВ. Зардлын эдийн засгийн ангилал

#### Урсгал зардлын бүлэг

- 3.1. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал:
  - 3.1.1. Үндсэн, нэмэгдэл, гэрээт ажилчдын цалинг ажилтны цалин олгох хүснэгт, цалингийн товчоо, удирдлагын ажилд томилох, чөлөөлөх тушаал шийдвэр, илүү цагийн тооцоо, ээлжийн амралт болон бусад нэмэгдлүүдийн тооцоо зэргийг үндэслэн олгоно. Цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын өглөг төлөх тохиолдолд эрх бүхий хяналтын байгууллагатай үйлдсэн тооцоо нийлсэн актыг хавсаргана.
  - 3.1.2. Урамшууллыг тухайн байгууллагын болон дээд шатны удирдлагын шийдвэр, тушаал, байгууллагын дотоод журам болон хамтын гэрээг үндэслэн олгоно.
  - 3.1.3. Унаа хоолны хөнгөлөлтийг олгохдоо цалин олгох хүснэгтийг үндэслэнэ.
- 3.2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл:

- 3.2.1. Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхдөө цалин олгох хүснэгт, цалингийн товчоо болон холбогдох бусад баримт бичгийг ирүүлнэ.
  - 3.2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг төлөх тохиолдолд эрх бүхий хяналтын байгууллагатай үйлдсэн тооцоо нийлсэн актыг хавсаргана.
- 3.3. Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал
- 3.3.1. Гэрэл, цахилгаан, түлш, халаалт, цэвэр, бохир ус зэрэг тогтмол зардлыг төлөхдөө байр ашиглалттай холбоотой гэрээ, нэхэмжлэгч байгууллагын тооцооны хуудас буюу төлбөрийн нэхэмжлэл зэргийг хавсаргана. Төсвийн байгууллага өөрийн уурын зуухтай тохиолдолд түүнтэй холбогдох зардлууд, тухайлбал, уурын зуухны ажиллагсдын нормын хувцас, хор тайлах сүү, үнс, нүүрс ачиж буулгах зардал, цэвэрлэгээний материал зэргийн төлбөрийг гүйцэтгэхдээ дээрх болон бусад холбогдох баримтуудыг хавсаргана.
  - 3.3.2. Байрны түрээсийн төлбөрийг гүйцэтгэхдээ түрээслэгч байгууллага, хувь хүнтэй байгуулсан гэрээ болон нэхэмжлэхийг үндэслэнэ.
- 3.4. Хангамж, бараа материалын зардал
- 3.4.1. Бараа материалыг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах тухай хууль болон энэ хуультай нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрийг баримтална.
  - 3.4.2. Төрийн үйлчилгээг хэвийн явуулахад зориулагдсан урсгал зардлыг бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, зарлагын баримтыг хавсаргана.
  - 3.4.3. Холбооны зардал зэрэг цахим хэлбэрээр ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн хийсэн төлбөр тооцоог улирал бүр тулган баталгаажуулсан байна.
- 3.5. Нормативт зардал
- 3.5.1. Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол, хүнс, нормын хувцас зэргийг худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг мөрдөнө.
  - 3.5.2. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн хязгаарт багтаан худалдан авалт хийсэн бол ажлын хэсгийн дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр, гүйцэтгэгч болон нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, нэхэмжлэх, орлогын болон зарлагын баримт зэргийг үндэслэнэ.
  - 3.5.3. Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн хязгаарт багтаан худалдан авалт хийсэн бол ажлын хэсгийн дүгнэлт, үнийн саналын харьцуулалт болон тавигдсан шалгуурт нийцсэн бэлтгэн нийлүүлэгчийг сонгосон шийдвэр, тэмдэглэл, байгуулсан гэрээ, бараа хүлээн авсан акт зэргийг хавсаргана.
  - 3.5.4. Нээлттэй тендер зарлах босго үнэ бүхий барааг худалдан авах бол бараа худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, бараа хүлээн авсан акт зэргийг хавсаргана.
- 3.6. Эд хогшил, урсгал засварын зардал
- 3.6.1. Багаж, техник, тавилга, хөдөлмөр хамгааллын хэрэглэл зэргийг худалдан авахдаа энэхүү зааврын 3.5 дахь заалтыг баримтална.
  - 3.6.2. Урсгал засварын зардлыг гүйцэтгэхдээ засварын төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, нэхэмжлэх, ажил хүлээлцсэн акт, захиалагчийг

төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажсан засварын ажлын гүйцэтгэл зэргийг үндэслэнэ.

- 3.7. Томилолт, зочны зардал
- 3.7.1. Гадаад албан томилолтын төлбөрийг гүйцэтгэхэд томилолтын тушаал, удирдамж, төсөв, замын зардлын нэхэмжлэх зэргийг хавсаргана.
- 3.7.2. Дотоод томилолтын зардлыг гаргахдаа томилолтын тушаал эсвэл томилолтын хуудас, төсөв зэргийг үндэслэнэ.
- 3.7.3. Томилолтын зам хоног байрны зардлыг Сангийн сайдын тушаалаар баталсан төсвийн хүрээнд хянаж, томилолтоор явах ажилтны харилцах дансанд шилжүүлэх эсвэл тухайн байгууллагын банкин дахь бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэх харилцах дансаар дамжуулан олгоно.
- 3.7.4. Зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг гүйцэтгэхдээ удирдлагын шийдвэр, төсөв, нэхэмжлэх зэргийг үндэслэн төлбөрийг гүйцэтгэнэ.
- 3.8. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
- 3.8.1. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг төлөхдөө гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ, нэхэмжлэх, ажил хүлээлцсэн акт зэрэг баримтуудыг хавсаргана.
- 3.8.2. Салбарын онцлогт хамаарах бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ холбогдох баримтыг хавсаргана.
- 3.9. Бараа үйлчилгээний бусад зардал
- 3.9.1. Бараа үйлчилгээний бусад зардалд хөтөлбөр, зориулалтаас хамааран байгууллага бүрд ялгаатай ажил үйлчилгээний зардлууд гарах ба эдгээртэй холбогдон гарах шийдвэр, бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх болон бусад холбогдох баримтыг хавсаргана.

#### **Хөрөнгийн зардлын бүлэг**

- 3.10 Хөрөнгийн зардлыг шилжүүлэхдээ бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, орлогын болон эрх нээсэн дансны хуулга зэргийг үндэслэн Сангийн сайдын баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ыг баримтлан гүйцэтгэнэ.
- 3.11 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлбөрийг гүйцэтгэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн газраас нээсэн эрхийг үндэслэн гүйцэтгэгчийн банкин дахь харилцах дансанд шилжүүлнэ.
- 3.12 Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд зөвхөн гэрээнд тусгасан барьцаа хөрөнгийг шилжүүлэн авах бөгөөд эдгээр барьцааг чөлөөлөхдөө орлогын хуулгыг үндэслэнэ.

#### **ДӨРӨВ. Нэмэлт санхүүжилт**

- 4.1 Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн эх үүсвэрийг зарцуулахдаа нэмэлт төсөв хариуцсан мэргэжилтний нээж өгсөн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, зориулалт, эдийн засгийн ангиллын эрхийн дагуу энэхүү зааварт дурдсантай адилаар холбогдох баримт бичгийг үндэслэн гүйцэтгэнэ.

## ТАВ. Бусад

- 5.1 Улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг, улсын төсвийн байгууллагуудад олгох санхүүжилт зэрэг урсгал шилжүүлгийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан төсвийн хуваарь, холбогдох журмыг үндэслэн шилжүүлнэ.
- 5.2 Орон нутгийн төсвийн санхүүжилтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан хуваарь, холбогдох журмыг үндэслэн гүйцэтгэнэ.
- 5.3 Улсын гадаад, дотоод бонд, гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж, газраас нээсэн эрхийг үндэслэнэ.
- 5.4 Эх үүсвэрээс үл хамааран Монголбанк болон бусад банкинд мөнгөн хадгаламж байршуулахдаа уг хадгаламжийн эх үүсвэр, үндэслэл, шалтгаан, зорилго зэргийг тусгасан Сангийн сайдын тушаал, хамтарсан тушаал, тухайн банктай хийсэн гэрээ, холбогдох нэгж, газраас нээсэн эрхийг үндэслэн гүйцэтгэнэ.
- 5.5 Улсын төсөв, Тогтворжуулалтын сангийн төсвөөс валютын арилжаа хийхдээ Монголбанкт хийсэн арилжааны хэлцлийг үндэслэн гүйцэтгэнэ.
- 5.6 Төсвийн байгууллагын гадаад төлбөр тооцоог Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дагуу гүйцэтгэнэ.
- 5.7 Орлого бууруулах гүйлгээ буюу хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсний тэтгэмж болон нэр, данс зөрүүгээс буцсан гүйлгээг шилжүүлэхэд тухайн бүртгэлийн дансны орлогын дэлгэрэнгүй хуулга, буцсан гүйлгээний хуулбарыг хавсаргана.